



Удирдлагуудад зориулсан манлайллын курс хөтөлбөр

“Менежмент нь хүмүүсийг зохион байгуулах тухай л асуудал юм”

—Петер Ф Друкер

Удирдагч хүнд өнөөгийн нийгэмд зах зээлийн өөрчлөлттэй хурдан зохицож, шинэ үе болон ахмад үеийн ажилтнуудыг удирдан ажиллахын зэрэгцээгээр бага нөөцөөр илүү үр дүнд хүрэх шаардлага гарцаагүй тулгарч байна. Хамтын ажиллагаа, гишүүдийн санал санаачилга, жигдрэл, тогтвортой байдал, шийдвэр сайжирснаар ажилтнууд өөрсдийн хүслийн дагуу амжилтад хүрэх нөхцөл бүрддэг.

Дэйл Карнеги Трэйнинг® таны захиалгын дагуу үр дүнтэй сургалтын хөтөлбөрийг тусгайлан боловсруулан хамтран ажилладаг. Та энэ сургалтад оролцоноор таны зорилгыг дэмжин, хамтарч ажиллах манлайлагчийг хэрхэн бий болгоход суралцах болно. Та өөрийн хүсэл тэмүүлэл, алсын харааг манай сургалтын өвөрмөц аргачлалтай хослуулснаар байгууллагын амжилтад хувь нэмрээ оруулж, дэмжлэг үзүүлэх ажилтнуудыг бий болгож чадна.

Ажилтнууд санаачилгатай, бүтээлч байх нь байгууллага тогтвортой өрсөлдөх чадварыг тодорхойлдог гол хүчин зүйл юм. Манлайллын зөв соёл нь инновац болон бүтээлч байдлыг дэмждэг.

Удирдлагуудад зориулсан манлайллын сургалтад удирдлагууд дараах зорилгоор оролцдог.

- Өөрчлөлтийн санал санаачилгыг бий болгож, хадгалах
- Үйл ажиллагаа, бодит ашгийг байнга нэмэгдүүл
- Байгууллагыг нэгдсэн алсын хараанд жигдрүүл
- Баримтад суурилсан шийдвэр гаргалтыг бүх шатанд хэвшүүлэх
- Стратегийн төлөвлөгөөг бэхжүүлж, хэрэгжүүлэх
- Байгууллагын бүх түвшинд итгэлцлийг бий болгон эрч хүчтэй ажиллах
- Хэрэглэгчийн үнэнч байдлыг хангах үнэт зүйлст суурилсан үйлчилгээний соёлыг бий болгох

Хэн оролцох вэ:

Байгууллагын гадаад болон дотоод хэрэглэгчидтэй харилцдаг ажилтан, төслийн удирдагч, багийн ахлагч болон манлайллын ур чадвараа сайжруулснаар өндөр амжилтад хүрэхийг хүсэж буй менежер, захирлууд.

Сургалтын дэлгэрэнгүй агуулга	Сургалтад оролцоноор та дараах чадваруудыг эзэмших болно:
Хувь хүний манлайлал болон байгууллагын манлайллын ялгааг ойлгох	<ul style="list-style-type: none"> • Сайн манлайлагчийн чанаруудыг тодорхойлох • Байгууллага дахь үүрэг хариуцлагыг тодорхойлох • Манлайллын 5 хүчин зүйлтэй танилцах
Инновацын үйл явц эхлүүлж, төлөвлөх, явцтай танилцах	<ul style="list-style-type: none"> • Инновацыг төрүүлдэг үйл явцыг илрүүлэх • Төлөвлөх 8 алхамт аргыг эзэмших • Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх
Ажлын гүйцэтгэлийг үйл явц, хариуцлага хүлээх чадварын талаарх ойлголттой танилцах, көүчинг хийх үнэлэх	<ul style="list-style-type: none"> • Гүйцэтгэлийн зорилтуудыг стратеги зорилттой жигдрүүлэх • Гүйцэтгэлийн стандартыг тодорхойлох • Ажилтнуудаа хариуцлагатай байлгах • Үр дүнтэй көүчинг хийх аргуудаас суралцах
Асуудалд анализ дүгнэлт хийх болон шийдвэр гаргах явцыг сайжруулах, хүний нөөц потенциалыг нээх	<ul style="list-style-type: none"> • Асуудлыг задлан шинжилж, шийдвэр гаргах аргуудыг эзэмших • Ажилтныхаа нуугдмал нөөц боломж, потенциалыг нээн илрүүлэх, үнэлэх
Сонсох үйл эх	<ul style="list-style-type: none"> • Ажилд томилох 8 алхамт аргачлалд суралцах • Алдааг анхааралтайгаар шийдвэрлэх • Ажилтнууддаа шинэ санааг хүлээж авахад туслах
Уулзалтыг үр дүнтэй удирдан, зохион байгуулахын тулд харилцах чадвараа сайжруулах	<ul style="list-style-type: none"> • Хамтын ажиллагаа, итгэлцлийг нэмэгдүүлэхийн тулд хүний харилцааны зарчмуудыг ашиглах • Нээлттэй харилцаа холбоог дэмжих • Сонсох ур чадварыг сайжруулах
Үргэлжлүүлэн хөгжиж дэвшихийн төлөө хичээн зүтгэх	<ul style="list-style-type: none"> • Ахиц дэвшлээ хадгалах болон үсрэнгүй амжилтын тэнцвэрт байдлыг хадгалах • Хувь хүний болон хамтын амжилтыг сайшаан урамшуулах